



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ДЭД ТАЙЛАН

“УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ”-Д ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГНАГ-2025/03-ШТА-НА

БАЯНХОНГОР АЙМАГТ БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН ХӨДӨӨ АЖ, АХУЙН
ЧИГЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙГДСЭН БОЛОВЧ ТҮҮНИЙГ ҮР АШИГТАЙ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРОН НУТГИЙН БОДЛОГО, ШИЙДВЭР ШААРДЛАГАТАЙ БАЙНА..

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу

Цахим хуудас: www.open.audit.mn

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер М.Алтантуяа

Утас: 70442424 цахим хуудас: Altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Азбаяр

Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn

Аудитор Д.Даваадорж

Утас: 88953144 цахим хуудас: Davaadorbj@audit.gov.mn

Баянхонгор хот 2025 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.open.audit.mn

Тайланг хянасан

Баянхонгор аймаг дахь Төрийн
аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Аудитын менежер М.Алтантуяа

Тайланг бэлтгэсэн:

Ахлах аудитор Б.Азбаяр
Аудитор Д.Даваадорж

2025 оны 4 дүгээр сарын 21-ны
өдөр

Уг тайланг УАГ-ын
цахим хуудаснаас үзнэ үү:
www.open.audit.mn

Аудитын тайлантай холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70442424 дугаарын утас,
70442584 дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ:

Баянхонгор аймаг дахь Төрийн
аудитын газар, Нутгийн
удирдлагын ордон,
Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум 64090,
Баянхонгор аймаг
Монгол Улс

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	3
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	4
БҮЛЭГ А. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН ШААРДЛАГА ХАНГАСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН ҮҮ?	5
АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС ХҮРГҮҮЛЖ БҮЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛЫГ ХАРГАЛЗАХҮЙГЭЭР ТӨСӨВ БАТЛАХ ТҮВШИНД ОРУУЛСАН АЖИЛ НЬ ТЭЗҮ ХИЙЖ БАТАЛГААЖААГҮЙ, ЦААШИД ТӨСӨВ НЭМЭГДЭХ ҮР ДАГАВАР ҮҮСЭХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА	5
1.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөсөн үү?	5
Баянхонгор аймагт 2024 онд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь улс, орон нутгийн урт, дунд хугацааны болон жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан байна.	5
1.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн эдийн засгийн үр ашгаа, нийгмийн ач холбогдлыг тооцож төлөвлөсөн үү?	6
ТЕЗ-чаас санал хүргүүлээгүй, эдийн засгийн тооцоо, шинжилгээ хийгдээгүй нийлүүлэгдсэн зарим тоног төхөөрөмж ашиглалтад ороогүй байгаа нь бодлогын түвшинд хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн уялдаа холбоо хангагдахгүй байгааг харуулж байна.	6
Аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагч нь сум болон төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудаас хөрөнгө оруулалтын санал авч, төсөл хэрэгжүүлэх шалтгаан, тулгамдаж буй асуудал, төслөөс гарах үр дүн, зорилтот бүлэг зэрэг 30 орчим үзүүлэлтээр нөхцөл байдлын шинжилгээ хийж, үнэлгээний оноо өгч эрэмбэлсэн байна.	6
1.3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хуульд заасан техник, эдийн засгийн үндэслэл, батлагдсан зураг төсөв, урсгал зардлын тооцоололтой, төсөвлөлтийн холбогдох бусад шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг тусгасан уу?	7
Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийхдээ Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтыг зөрчсөн байна.	7
1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцсэн, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн үү?	8
Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцсэн, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.	8
БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮҮ?	9
ТЕНДЕРИЙН ТОДОРХОЙЛОЛТЫГ ОНОВЧТОЙ БОЛОВСРУУЛААГҮЙГЭЭС БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭГ ЧАНАРГҮЙ НИЙЛҮҮЛЭХ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД МАРГААН ҮҮСЭХ ШАЛГААН БОЛСОН БАЙНА	9
2.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааны журмыг сонгох үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан уу?	9
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуулийн хугацаанд нь баталж, цахим системийн хэрэгжилтийг ханган, тендерийн үйл явцыг ил тод, нээлттэй зохион байгуулсан байна.	9
2.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, батлуулсан уу?	10
Тухайлбал: Спортын тоног төхөөрөмж нийлүүлэх худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолтод Волейболын шал, чөлөөт бөхийн дэвжээ, байтын болон үндэсний сурын нум сумны иж бүрдэл зэрэг хөрөнгүүдэд тавигдах гол гол харьцуулах шаардлагыг тусгаагүй ерөнхий нэрээр нь оруулж өгсөн нь нийлүүлэгч чанаргүй, хэт өдөр үнэлгээтэй бараа нийлүүлэхэд хүргэсэн байна.	10
2.3. Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан уу?	12
БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ САНХҮҮЖҮҮЛЖ, ХУГАЦААНД НЬ ГҮЙЦЭТГҮҮЛЭН БҮРТГЭЛД ТУСГАСАН ҮҮ?	13
ТӨСВӨӨС ОЛГОХ САНХҮҮЖИЛТИЙГ ЦАГ ТУХАЙ БҮР ОЛГОЖ БАЙХАД АЖЛАА ЦАГ ХУГАЦААНДАА ГҮЙЦЭТГЭХҮЙ АЖИЛ УДААШРУУЛАХ БАЙДАЛ ГАРСАН БАЙНА	13
3.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль журмын дагуу санхүүжүүлсэн үү?	13
Санхүүжилтийг зохиогчийн болон захиалагчийн хяналтын тайлан ажлын тоо хэмжээ нэг бүрээр тулгаж олгосон байна.	13
3.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж, гэрээг дүгнэсэн үү?	14
Төсвийн тухай хуулиар хэрэгжиж дуусах хугацаа болсон гэрээний хугацаа дууссан 3 төсөл, арга хэмжээний хэрэгжилт бүрэн дуусаагүй байна.	14
3.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлж, холбогдох хууль журамд нийцүүлэн хүлээн авсан уу?	15
Хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн тоног төхөөрөмжийг хүлээн авахдаа комисс дутуу хүлээн авсан байна.	15
3.4. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна уу?	21
ДҮГНЭЛТ:	23
ЗӨВЛӨМЖ:	24

Товчилсон үгийн тайлбар

АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОН	Орон нутаг
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
УИХ	Улсын Их Хурал
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ЦТС	Цахилгаан түгээх сүлжээ
ЭЗТХ	Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтэс
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн төсөвт үйлдвэрийн газар
ТШЗ	Тендер шалгаруулалтын зааварчилгаа
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийн уялдаа холбоо	5
Хүснэгт 2	Зураг төсөв шаардлагатай ТАХ	7
Хүснэгт 3	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаа	9
Хүснэгт 4	Түүвэр хийсэн харьцуулалт	11
Хүснэгт 5	ТЕЗ-чийн санхүүжилтийн ангилал	13
Хүснэгт 6	Эрх шилжиж ирсэн барилга байгууламжийн хэрэгжилт	15

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоолыг үндэслэн хийв.
Аудитын зорилт	Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг УАГ-ын ГНАГ болон аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. - Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх. - Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллага, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуй нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулан төлөвлөлт, судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн нийцлийн аудитыг хийв. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймагт хэрэгжихээр өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж буй 190,105.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 60,069.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 28 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан ба тайлант онд шинээр 147,690.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 43,176.3 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 23 төсөл хэрэгжүүлэхээр баталсан байна. Дээрх 51 төсөл арга хэмжээнээс 162,284.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 55,150.4 сая төгрөгийн 28 төсөл арга хэмжээг Баянхонгор аймгийн Засаг даргад эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн байна.
Аудитын хязгаарлалт	Аудитад Монгол Улсын 2024 онд төсвийн тухай хуулиар батлагдаж аймгийн ТЭЗ-чид эрх шилжиж ирсэн ТАХ-нээс бусад эх үүсвэрээр хийгдсэн төсөл, арга хэмжээг хамруулаагүй болно.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ(INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 400, 3000-3001, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020, Гүйцэтгэлийн аудитын зарчим, 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авч, харьцуулалт хийн, нэгтгэн, дүн шинжилгээ хийж, аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер М.Алтантуяа хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор Д.Даваадорж нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс эхлүүлж, аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2025 оны 03 дугаар сарын 06-аас 04 дүгээр сарын 10-ны хооронд гүйцэтгэж, тайлагналын үе шатны ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлүүлж, тайланг 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр газрын дарга, тэргүүлэх аудитораар баталгаажуулан ҮАГ-ын ГНАГ болон аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох бусад байгууллагуудад хүргүүлэв.

Хүндрэл
бэрхшээл

Байхгүй

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймагт хэрэгжихээр өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж буй 190,105.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 60,069.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 28 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан ба тайлант онд шинээр 147,690.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 43,176.3 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 23 төсөл хэрэгжүүлэхээр баталсан байна.

Дээрх 51 төсөл арга хэмжээнээс 162,284.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 55,150.4 сая төгрөгийн 27 төсөл арга хэмжээг Баянхонгор аймгийн Засаг даргад эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн байна.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ А. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН ШААРДЛАГА ХАНГАСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН ҮҮ?

АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС ХҮРГҮҮЛЖ БҮЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛЫГ ХАРГАЛЗАХГҮЙГЭЭР ТӨСӨВ БАТЛАХ ТҮВШИНД ОРУУЛСАН АЖИЛ НЬ ТЭЗҮ ХИЙЖ БАТАЛГААЖААГҮЙ, ЦААШИД ТӨСӨВ НЭМЭГДЭХ ҮР ДАГАВАР ҮҮСЭХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА.

1.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөсөн үү?

Баянхонгор аймагт 2024 онд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь улс, орон нутгийн урт, дунд хугацааны болон жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан байна.

Улсын төсвийн хөрөнгөөр Баянхонгор аймагт 2024 онд 34,942.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 17,890.4 сая төгрөгийн санхүүжүүлэх дүнтэй 10 төсөл арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд аудитаар төсөл арга хэмжээг төлөвлөхдөө урт, дунд, богино хугацааны бодлоготой уялдсан байдлыг авч үзэв.

Хүснэгт№ 1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийн уялдаа холбоо.

Д/Д	Төсөл арга хэмжээний нэр	Богино, дунд хугацааны бодлогын баримт бичиг	Бодлогын баримт бичгийн зүйл заалт, уялдаа
1	Цэцэрлэгийн барилга /Бөмбөгөр сум/ XIII.1.1.344	Монгол улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө 2024, Алсын хараа 2050, 2024 оны худалдан авах ажиллагааны хөтөлбөр	Монгол улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө 2024, 3.1.5, Алсын хараа 2050 2.3.4,
2	Сургуулийн барилга, /Соого сэйкео сургууль/ XIII.1.1.303	Монгол улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө 2024, Алсын хараа 2050, 2024 оны худалдан авах ажиллагааны хөтөлбөр	Монгол улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө 2024, 3.1.5, Алсын хараа 2050 2.3.4,
3	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/ XII.1.4	Алсын хараа 2050,	Алсын хараа 2050 5.2.9
4	Малчдын хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын тоног төхөөрөмж. XIII.1.3.33	МУ-ын ЗГ-ын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр, 2024 оны худалдан авах ажиллагааны хөтөлбөр, Баянхонгор аймгийн засаг даргын 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр	МУ-ын ЗГ-ын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр 2.3.11, Баянхонгор аймгийн Засаг даргын 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.3.3.1
5	Биеийн тамир, спортын салбарын тоног төхөөрөмж /Баянхонгор/ XVI.3.3.1	Монгол улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө 2024, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Монгол улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө 2024 3.3.3.3, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 3.5.1
6	"Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын ажилчдын байр, халуун усны байр /Баянхонгор, Баянхонгор сум/ XVII.1.71	Монгол улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө 2024	Монгол улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө 2.5.12
7	Шинэ хөдөө" төсөл /Баянхонгор/ XVII.1.71	Монгол улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө 2024, Алсын хараа 2050, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Монгол улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө 2024 3.3.8, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 8.3.13
8	Наркологийн төв эмнэлгийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/ XXI.1.49	Монгол улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө 2024, Алсын хараа 2050,	Алсын хараа 2050 - 2.2.27.

Улс, орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

9	Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Баянхонгор/ XXI.3.22	МУ-ын ЗГ-ын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр	МУ-ын ЗГ-ын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр 2.1.4.2
10	Малчид болон орон нутгийн хөгжлийг дэмжих "Мал аж ахуйн салбарын эдийн засгийн үр ашиг, хөдөлмөрийн бүтээмж" төслийн тоног төхөөрөмж /Баянхонгор/ XVIII.3.17	Монгол улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө 2024, Алсын хараа 2050	Монгол улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө 2024 3.3.8

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь Монгол Улсын 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө, "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, мөн Баянхонгор аймгийн Засаг даргын 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаж, нийцэж байна.

1.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож төлөвлөсөн үү?

ТЕЗ-чаас санал хүргүүлээгүй, эдийн засгийн тооцоо, шинжилгээ хийгдээгүй нийлүүлэгдсэн зарим тоног төхөөрөмж ашиглалтад ороогүй байгаа нь бодлогын түвшинд хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн уялдаа холбоо хангагдахгүй байгааг харуулж байна.

Аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагч нь сум болон төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудаас хөрөнгө оруулалтын санал авч, төсөл хэрэгжүүлэх шалтгаан, тулгамдаж буй асуудал, төслөөс гарах үр дүн, зорилтот бүлэг зэрэг 30 орчим үзүүлэлтээр нөхцөл байдлын шинжилгээ хийж, үнэлгээний оноо өгч эрэмбэлсэн байна.

Дээрх эрэмбийн хүрээнд нийт 50 төсөл, арга хэмжээг 55.5–79.5 оноогоор үнэлж, 364,988.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий саналыг салбарын чиг үүрэг бүхий 8 яаманд хүргүүлсэн байна. Уг саналуудыг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлсний үр дүнд 104,296.7 сая төгрөгийн өртөгтэй 10 төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд тусган баталсан байна. (Мэдээллийг Баянхонгор аймгийн эрх шилжсэн болон эрх шилжээгүй нийт төсөл арга хэмжээний хувьд авч үзэв)

Салбарын яамнаас бодлогоор буюу УИХ гишүүдийн санаачлагчаар дараах тоног төхөөрөмжүүдийг төсөвт батлуулж эрх шилжин ирж хэрэгжсэн байна.

- Малчдын хүүхдийн сурагуулийн өмнөх боловсролын тоног төхөөрөмж 1,000.0 сая төгрөг
- Малчид болон орон нутгийн хөгжлийг дэмжих "Мал аж ахуйн салбарын эдийн засгийн үр ашиг, хөдөлмөрийн бүтээмж" төслийн тоног төхөөрөмж 1,000.0 сая төгрөг
- "Шинэ хөдөө" төсөл 3,000.0 сая төгрөг
- Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж 900.0 сая төгрөг
- Биеийн тамир, спортын салбарын тоног төхөөрөмж 600.0 сая төгрөг

Монгол Улсын Ерөнхий Сайдын Баянхонгор аймагт 2023 оны 9 дүгээр сард иргэдтэй хийх уулзалтын үеэр иргэд болон ажил хариуцсан зарим албан тушаалтнуудын хүсэлтийг сонсож зарим хөрөнгө оруулалтын асуудлыг шийдсэн бөгөөд уг хурлын тэмдэглэл, гаргасан санал зэргээс үзэхэд "Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын

ажилчдын байр, халуун усны байр зэрэг зарим төсөл, арга хэмжээг улсын төсөвт батлуулахаар амлалт өгсний дагуу төсөвт туссан байна.

Аудитын илрүүлэлт:

- Харин ТЕЗ-чаас санал хүргүүлээгүй, эдийн засгийн тооцоо шинжилгээ хийгээгүй Шинэ хөдөө төсөл, Малчид болон орон нутгийн хөгжлийг дэмжих "Мал аж ахуйн салбарын эдийн засгийн үр ашиг, хөдөлмөрийн бүтээмж" төслийн хүрээнд нийлүүлэгдсэн зарим тоног, төхөөрөмж нь ашиглалтгүй байгаа нь төсвийн хөрөнгийн үр ашиг бүрэн гарахгүй байна. Тухайлбал: Шинэ хөдөө төслийн хөрөнгө оруулалтаар ирсэн Баянхонгор үйлдвэрлэл хөгжлийн корпорац ОНӨҮГ-т хуваарилсан Китлийн 80 ш тоног төхөөрөмж ирснээс 52 ш нь ашиглалтгүй байна.

Хэрэгцээ, шаардлагыг бүрэн тодорхойлж, ач холбогдлоор нь эрэмбэлсэн төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгуулах, орон нутгийн түвшинд тодорхойлсон хөгжлийн бодлогыг дэмжих чиглэлээр холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэх саналыг Үндэсний аудитын газрын ГНАГ-т газарт уламжлав.

1.3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хуульд заасан техник, эдийн засгийн үндэслэл, батлагдсан зураг төсөв, урсгал зардлын тооцоололтой, төсөвлөлтийн холбогдох бусад шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг тусгасан уу?

Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийхдээ Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд эрх шилжүүлсэн 28 төсөл арга хэмжээнээс зураг төсөв шаардлагатай 8 төсөл, арга хэмжээ нь техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон эсэхийг аудитын явцад шалгалаа.

Хүснэгт 2. Зураг төсөв шаардлагатай ТАХ

Дд	Төсөл арга хэмжээний нэр	Магадлалын дүгнэлт гарсан огноо	Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалттай нийцсэн эсэх	Тайлбар
1	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/	2024.05.16	Үгүй	
2	"Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын ажилчдын байр, халуун усны байр /Баянхонгор, Баянхонгор сум/	2024.03.20	Үгүй	
3	Сургуулийн барилга, 640 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, Соого сейкео сургууль/	2024.04.25	Үгүй	
4	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баянхонгор, Бөмбөгөр сум/	2024.05.20	Үгүй	
5	Наркологийн төв эмнэлгийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/	2024.06.10	Үгүй	
6	Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Багц 2.1: Орон нутгийн цахилгаа	-	Үгүй	

Эх сурвалж: 2022 оны УТ 6.1.4. Хэрэгжүүлэх ТАХ-ны судалгаа

Харин дээрх 6 төсөл арга хэмжээ нь улсын төсөв батлагдсанаас хойш зураг төсөв боловсруулсан, магадлалаар баталгаажуулах ажлыг зохион байгуулсан нь

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹ дэх заалтыг зөрчих байдал арилахгүй байгааг харуулж байна.

Төсвийн тухай хууль зөрчиж баталсан хэдий ч төсөвт батлагдсан хөрөнгийн үр ашгийг орон нутаг хүртэх шаардлагатай байгаагаас худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа талаар аймгийн Худалдан авах ажиллагааны дарга тайлбар өгөв. Төсөвт магадлал хийгээгүй, зураг төсвийг магадлалаар батлаагүй арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлснээр цаашид төсөв нэмэгдэх, ажил удаашрах хөрөнгийн үр ашиг бүрэн гарахгүй байх, чанаргүй ажил гүйцэтгэх үр дагавар үүсэж байна.

Иймд төсөл, арга хэмжээний төсөвлөлтийн шалгуурт магадлалын дүгнэлтийг авч үзэж байх зөвлөмжийг холбогдох газарт хүргүүлэх саналыг УАГ-ын ГНАГ-т хүргүүлэв.

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар 8 төсөл арга хэмжээнээс 6 нь ТЭЗҮ-гүй баталж байсан бол энэ зөрчил нь тайлант онд буураагүй байна.

1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцсэн, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн үү?

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцсэн, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Баянхонгор аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүд нь улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжтой, нийтийн зориулалттай, техник, эдийн засгийн үндэслэл хийгдэж зураг төсөв нь батлагдсан төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Тендер шалгаруулалтаас шалтгаалан Наркологийн төвийн барилга угсралтын ажлын худалдан авах ажиллагаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1 “батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах” хугацаа хэтэрч 2024 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр гэрээ байгуулан барилгын ажил эхлүүлсэн байна. Энэ нь барилгын ажил төлөвлөсөн хугацаанаасаа удаашрах шалтгаан болсон байна.

Иймд цаашид худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлийн хууль болон бусад хууль тогтоомжоор заасан хугацаанд багтаан худалдан

¹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

авах ажиллагааг зохион байгуулж байх зөвлөмжийг аймгийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэв.

БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН УУ?

ТЕНДЕРИЙН ТОДОРХОЙЛОЛТЫГ ОНОВЧТОЙ БОЛОВСРУУЛААГҮЙГЭЭС БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭГ ЧАНАРГҮЙ НИЙЛҮҮЛЭХ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД МАРГААН ҮҮСЭХ ШАЛГААН БОЛСОН БАЙНА.

2.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааны журмыг сонгох үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан уу?

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуулийн хугацаанд нь баталж, цахим системийн хэрэгжилтийг ханган, тендерийн үйл явцыг ил тод, нээлттэй зохион байгуулсан байна.

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Аймгийн Засаг дарга 2023 оны 11 дүрээр сарын 21-ний өдөр баталж тайлант хугацаанд 2 удаа тодотгон баталсан байна.

Төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх 34,942.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17,890.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 13 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн хооронд зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 13 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулан хэрэгжүүлэх эрхийг салбар салбарын харьяа яам болон Засгийн газрын тогтоол шийдвэрээр тухай бүрд нь Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжүүлсэн байна.

Хүснэгт № 3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаа

№	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	2024 онд санхүүжилт	Гэрээний дүн	Эрх шилжсэн шийдвэр
1	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга	2,322.5	500.5	2,180.9	БОАЖС-ын 2023.12.2-ний өдрийн А/641 дугаар тушаал
2	Сургуулийн барилга, 640 суудал Соого сейкео сургууль	13,329.0	13,329.0	13,308.0	ЗГ-ын 2024.01.17-ний өдрийн 26 дугаар тогтоол
3	Цэцэрлэгийн барилга, 100 ор Бөмбөгөр сум	2,600.00	2,600.00	2,551.4	БШУЯ-ын 2023.12.05-ны өдрийн А/550 дугаар тушаал
4	Малчдын хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын тоног төхөөрөмж	1,000.00	1,000.00	998.1	ЗГ-ын 2023.11.22-ны өдрийн 409 дүгээр тогтоол
5	Биеийн тамир, спортын салбарын тоног төхөөрөмж	600.0	600.0	569.5	ЗГ-ын 2023.11.22-ны өдрийн 409 дүгээр тогтоол
6	Цэвэр хот ОНӨААТҮГ-ын ажилчдын байр, халуун усны байр	1,000.0	500.0	970.8	ЗГ-ын 2023.11.22-ны өдрийн 409 дүгээр тогтоол
7	Шинэ хөдөө төсөл	3,000.0	3,000.0	2,796.4	ЗГ-ын 2023.11.22-ны өдрийн 409 дүгээр тогтоол
8	Малчид болон орон нутгийн хөгжлийг дэмжих "Мал аж ахуйн салбарын эдийн	1,000.0	1,000.0	800.0	ЗГ-ын 2023.11.22-ны өдрийн 409 дүгээр тогтоол

засгийн үр ашиг, хөдөлмөрийн бүтээмж төслийн тоног төхөөрөмж					
9	Наркологийн төв эмнэлгийн барилга	7713.8	2,314.1	7,494.1	ЭМС-ын 2024.01.09-ний өдрийн А/12 дугаар тушаал БОАЖС-ын 2024.01.19-ний өдрийн А/38 дугаар тушаал ЭХС-ын 2024.01.31-ний өдрийн 4/48 дугаар тушаал
10	Эрүүл мэндийн салбарын тоног	900	900	894.4	
11	Шинэжинст сумын цаг уурын өртөөний барилгын засварын ажил	65.0	65.0	64.9	
12	Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж	422.6	422.6	418.8	
13	Хөдөө аж ахуйн кластер төсөл	990.0	990.0	919.9	
Нийт дүн		34,942.9	17,890.4	33,919.0	

Сангийн сайдын 2023 оны 248 дугаар тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагааны цахим системээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын хэрэгжилтийг бүрэн хангаж цахим системд тендерийн урилга, үр дүнг тухай бүр оруулан гүйцэтгэгчийг ил, тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган ажилласан байна.

2.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, батлуулсан уу?

Тендерийн баримт бичигт техникийн тодорхойлолт болон хууль эрх зүйн шаардлагыг хангалттай нарийвчлалтай оруулаагүйгээс чанаргүй, хэрэгцээ шаардлагад нийцээгүй, зах зээлийн үнээс өндөр үнээр нийлүүлэх бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх нөхцөл үүсэж байна.

Тендерт оролцогчийн тендерт бэлтгэж ирүүлэхэд шаардагдах мэдээлэл, оролцогчид тавих шаардлага, заавар, шалгаруулах шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн гол гол жишиг маягтыг тендер шалгаруулалтын баримтад тусгаж Худалдан авах ажиллагааны газрын дарга тухай бүрд баталсан байна.

Зарим нэг тендерийн бичиг баримтад тусгагдсан техникийн тодорхойлолтод захиалагчийн бараа ажил үйлчилгээнд тавигдах шаардлагаа нарийн тодорхойлж өгөөгүй, тендерт оролцогчид тавигдаж байгаа шаардлага барилгын салбарын хуульд нийцэхгүй байх заалт оруулж баталсны улмаас чанаргүй, хэрэгцээ шаардлагад нийлцэхгүй бараа ажил үйлчилгээ нийлүүлэх, худалдан авах ажиллагаа хугацаандаа хийгдэхгүй барилгын ажил эхлүүлэх хугацаа удааширч ажил хугацаандаа хийгдэхгүй байх нөхцөл байдал үүссэн байна.

Тухайлбал: Спортын тоног төхөөрөмж нийлүүлэх худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолтод Волейболын шал, чөлөөт бөхийн дэвжээ, байтын болон үндэсний сурын нум сумны иж бүрдэл зэрэг хөрөнгүүдэд тавигдах гол гол харьцуулах шаардлагыг тусгаагүй ерөнхий нэрээр нь оруулж өгсөн нь нийлүүлэгч чанаргүй, хэт өдөр үнэлгээтэй бараа нийлүүлэхэд хүргэсэн байна.

Хүснэгт № 4 Түүвэр хийсэн харьцуулалт

№	Барааны нэр	Захиалагчийн техникийн тодорхойлолт, хэмжээ	Хүлээлгэн өгсөн барааны тодорхойлолт	Тайлбар
1	Волейболын шал	1300м2, Материал резин	729 м2 Материал резин	571 м2 дутуу нийлүүлсэн, техникийн тодорхойлолтод стандарт болон харьцуулах жишиг барааг зааж өгөөгүйгээс шалтгаалан чанаргүй нийлүүлэгдсэн байна. Ашиглагч байгууллагын тайлбараар шал нь нимгэн, олон хэсэг салдаг зүүдэл ихтэй, байрлуулах явцад урагдсан байна.
2	Чөлөөт бөхийн дэмжээ	3 ком 72 ширхэг 3 хос дэвжээ	3 ком 72 ширхэг 3 хос дэвжээ	Жүдо бөхийн дэвжээний техникийн тодорхойлолт порлон дотортой савхин гэж зааж түүний дагуу нийлүүлэгдсэн бол чөлөөт бөхийн дэвжээний техникийн тодорхойлолтод стандартыг нарийн зааж өгөөгүйгээс шалтгаалан чанаргүй дэвжээ ирсэн байна. Дэвжээний дотор материалын хувьд цахилгаан барааны дотор тусгаарлалт хийдэг хөөсөнцрөөр хийсэн нь чанарын хувьд муу нийлүүлэгдсэн байгааг нотолж байна.
3	Нум сумны иж бүрдэл	Нум, сум, хасаа, эрхийвч, агсуурга	Нум, сум, хасаа, эрхийвч, агсуурга	Техникийн тодорхойлолтод стандарт болон харьцуулах жишиг барааны мэдээлэл тусгаж өгөөгүйгээс зах зээлийн үнээс өндөрөөр нийлүүлэгдэж 4 нум сумны хасаа ирээгүй байна. Зах зээлийн ханш 1,5 сая төгрөг байхад 2.5 сая төгрөгөөр нийлүүлсэн

Тендерийн санал нь зах зээлийн үнээс өндөр үнээр нийлүүлэх тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар хуульд зохицуулалт байхгүй байна.

Иймд ТБОНӨХБАҮХАТ-хуульд тендерийн тодорхойлолтод дүн шинжилгээ хийж, зах зээлийн үнийг судалж, шийдвэр гаргах зохицуулалтыг оруулах шаардлагатай байна.

Наркологийн төвийн барилгын ажил угсралтын тендерийн бичиг баримтад тендерт оролцогчид тавигдах ТШЗ өгөгдлийн хүснэгтийн 19.1.3-т барилга угсралтын ажил хийсэн байх гэж зааж өгсөн нь Барилгын тухай хуульд 4.1.11."барилгын ажил" гэж бүх төрлийн барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэх талбайг бэлтгэх, бүрдэл хэсгийг угсрах, шинэчлэн барих, буулгах, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулах үйл ажиллагааг" гэж заасантай нийцэхгүй тендерийн хугацааг удаашруулах, маргаан үүсэх шалтгаан болсон байна.

Иймд Тендерийн баримт бичгийн техник болон хууль эрх зүйн шаардлагыг салбарын холбогдох хуульд нийцүүлэн боловсруулж байх, шалгуур үзүүлэлтийг харьцуулах боломжтой тодорхой, ойлгомжтой оруулж ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49.4.10 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн Худалдан авах ажиллагааны газарт өгөв.

2.3. Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан уу?

Аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчид шинээр хэрэгжүүлэх 13 төсөл арга хэмжээ эрх шилжиж ирснээс 12 төсөл арга хэмжээг хуулийн дагуу зохион байгуулсан байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь эрх шилжин ирсэн Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих 34,942.9 сая төгрөгийн өртөг бүхий 13 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж 33,919.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гэрээ байгуулсан бөгөөд худалдан авах ажиллагааны үр дүнгээр бага үнийн саналаар шалгаруулж 1,023.7 сая төгрөгийн хэмнэлт гарах нөхцлийг бүрдүүлсэн байна.

Аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчид шинээр хэрэгжүүлэх 13 төсөл арга хэмжээ эрх шилжиж ирснээс 12 төсөл арга хэмжээг хуулийн дагуу зохион байгуулсан байна.

Харин наркологийн төвийн тендэр шалгаруулалтыг 3 удаа зохион байгуулж тендерийн бичиг баримт ТШЗ-ны 19.1-т тусгасан шалгуур хангаагүй оролцогчийг шалгаруулсан байна.

Тендер шалгаруулалтын хүрээнд тендэрт оролцсон Итгэл тайж ХХК болон Бүрэн одод ХХК нь тус бүр гомдол гаргасныг Сангийн яамнаас хоёр удаа хянаж шийдвэрлэсэн. Тендэрийн бичиг баримт ТШЗ-ны 17.3 Түшлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18,19 “чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна”, 19.1 “хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлага хагасан байна” Өгөгдлийн хүснэгт 19.1.3 батлагдсан төсөв өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй / ижил төстэй ажилд барилга угсралтын ажилыг тооцно/ ажил гүйцэтгэсэн байна гэж заасан.

- 2024 оны 6 сарын 18-нд Үнэлгээний хороо хуралдаж Итгэл тайж ХХК-ыг шалгаруулсан шийдвэр гаргасан боловч Бүрэн Одод ХХК компани нь ТШЗ 19.1.3-т заасан шаардлагыг хангаагүй талаар гомдол гаргаж Сангийн яамнаас 2024 оны 6 сарын 27-нд 03/5622 дугаар албан бичгээр тус шалгаруулалтыг түдгэлзүүлсэн.
- 2024 оны 7 сарын 25-нд Үнэлгээний хороо дахин хуралдаж Бүрэн одод ХХК-ыг шалгаруулахдаа Бүрэн одод ХХК-ыг ТШЗ 19.1.3-т заасан шаардлага хангаагүй байхад шалгаруулсан.
- Итгэл тайж ХХК нь Сангийн яаманд гомдол гаргаж, Сангийн яамнаас 2024 оны 8 сарын 12-нд 03/6736 дугаар албан бичгээр тус гомдлыг үндэслэлтэй гэж үзэн дахин түдгэлзүүлсэн.
- Үнэлгээний хороо 2024 оны 8 сарын 21-нд эцсийн хуралдаанаар Итгэл тайж ХХК болон түншлэгч Жи жи ай ХХК-ыг шалгаруулсан боловч түншлэгч Жи жи ай ХХК нь ТШЗ 19.1.3-т заасан барилга угсралтын ажил гүйцэтгэсэн байх шаардлагыг хангаагүй байна.

Сангийн яам гүйцэтгэгч 2 компани тус бүр гомдол гаргасныг үндэслэлтэй гэж үзэн дахин үнэлгээ хийх талаар бичиг ирүүлсэн байхад Итгэл тайж ХХК-ийг шалгаруулсан нь тендерийн бичиг баримтад заасан “барилга угсралтын ажил хийсэн”

гэж “Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд цаашид тендерийн баримт бичигт туссан ерөнхий шаардлагыг үнэлэх талаар үнэлгээний хорооны гишүүдэд арга, зүйн зөвлөгөө өгч ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын даргад зөвлөмжөөр хүргүүлэв.

БҮЛЭГ 3. хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан уу?
төсвөөс олгох санхүүжилтийг цаг тухай бүр олгож байхад ажлаа цаг хугацаандаа гүйцэтгэхгүй ажил удаашруулах байдал гарсан байна.

3.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль журмын дагуу санхүүжүүлсэн үү?

Санхүүжилтийг зохиогчийн болон захиалагчийн хяналтын тайлан ажлын тоо хэмжээ нэг бүрээр тулгаж олгосон байна.

Баянхонгор аймгийн Засаг даргад эрх шилжсэн 28 төсөл, арга хэмжээний нийт 40 багц ажилд 61,690.4 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн Төрийн сангийн дансаар дамжуулан олгосон байна. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжин ирсэн дүнгээр авч үзвэл:

Хүснэгт № 5. ТЕЗ-чийн санхүүжилтийн ангилал

№	Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр	Төсөл, арга хэмжээний тоо	Багцын тоо	Гэрээний дүн	Санхүүжүүлсэн дүн	ТАХ-нд олгосон	Барьцаа дансанд байршуулсан дүн
1	БШУС	9	10	32,078.5	10,953.0	10,384.7	568.3
2	БОУАӨС	1	1	2,180.9	500.0	500.0	-
3	ЭМС	3	3	10,058.9	2,786.9	2,658.6	128.2
4	БХБС	6	6	53,265.9	24,449.8	21,319.9	3,129.8
5	ОНБТСҮХ	2	2	13,660.9	669.5	641.1	28.5
6	ХХААХҮС	4	15	26,044.8	11,222.7	10,070.5	1,152.2
7	ЗТХС	1	1	7,995.2	3,380.7	2,566.5	814.2
8	Эрчим сайд хүчний	2	2	13,715.4	7,727.8	7,042.0	685.8
	ДҮН	28	40	159,000.5	61,690.4	55,183.4	6,507.0

Аудитаар төсөл, арга хэмжээ тус бүрийг газар дээр нь очиж гүйцэтгэл гаргасан санхүүжилтийн баримтыг гаргасан ажлын гүйцэтгэлийн хувьтай тулган шалгахад ажил тус бүрээр хяналтын хуудас хөтөлж, зохиогчийн болон захиалагчийн хяналтын тайланг авч ил, далд ажлын актыг баримтжуулан фото зургаар баталгаажуулан санхүүжилтийг хянаж олгосон байна. /Төсөл, арга хэмжээ тус бүрээр санхүүжилтийн гүйцэтгэлийг хавсралт судалгаагаар харуулав./

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хүрээнд техник хяналтын зардалд 785.7 сая, нормчлолын санд 89.0 сая,

зураг төсөв зохиогчийн хяналтын зардалд 1,361.8 сая, барьцаа дансанд 6,507.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй ГХБХБГ нь 2024 онд барилга угсралтын ажилд хяналтын нэг инженер, шугам сүлжээ дэд бүтэц хариуцсан нэг инженер аймгийн хэмжээнд улс, орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй 70 орчим барилга угсралтын ажилд хяналт хэрэгжүүлсэн бөгөөд 1 объектод дунджаар 3 удаа хяналт хэрэгжүүлэхэд 220 орчим удаагийн хяналт хийж байгаагаас үзэхэд хүний нөөцийн хүрэлцээ дутмаг байна.

Энэ нь цаашид чанаргүй барилга баригдах, төсөл арга хэмжээний төлөвлөсөн үр ашиг бүрэн гарахгүй байх үр дагавар үүсэж байна.

Иймд Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.9²-д заасны дагуу зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хуулийн этгээдээр хяналтыг гүйцэтгүүлэх боломж байгааг аймгийн Засаг даргад зөвлөмжөөр хүргүүлэв.

Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын нийт 63,907.8 сая төгрөгийн санхүүжилтээс 61,690.4 сая төгрөгийн эрхийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дансаар нээлгэж, төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна. Гэвч тендер шалгаруулалт удааширсан шалтгаанаар Наркологийн төв эмнэлгийн барилгын ажлыг хэрэгжүүлэхэд зориулан тусгасан 774.7 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн ашиглаж чадаагүй, улмаар тухайн хөрөнгө оруулалтын боломжийг алдсан байна.

3.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж, гэрээг дүгнэсэн үү?

Төсвийн тухай хуулиар хэрэгжиж дуусах хугацаа болсон гэрээний хугацаа дууссан 3 төсөл, арга хэмжээний хэрэгжилт бүрэн дуусаагүй байна.

Баянхонгор аймагт эрх шилжсэн 28 төсөл арга хэмжээнээс 76,639.0 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээ нь 2024 оны төсвийн жилд багтан гэрээний үүргийн биелэлтийг хангаж ажлыг бүрэн хүлээлгэн өгч гэрээгээ дүгнүүлсэн байна.

Харин 64,430.4 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээ нь он дамжин хэрэгжиж байгаагаас гэрээний хугацаа дуусаагүй хэрэгжилтийн шатандаа байна.

Аудитын илрүүлэлт:

Монгол улсын Төсвийн тухай хуульд хэрэгжиж дуусах хугацаа дууссан 14,178.9 сая төгрөгийн дараах 3 төсөл, арга хэмжээ нь гэрээний хугацаа дууссан боловч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, ажлаа бүрэн хийж дуусгаагүй байна. Үүнд:

² Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилга байгууламжийн захиалагч нь Барилгын тухай хуулийн 37.2-т заасны дагуу барилга захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий төрийн өмчит хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх, эсхүл холбогдох чиглэлээр бүртгүүлсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хуулийн этгээдийг сонгон ажиллуулж болно.

1. Баянхонгор аймгийн Баянхонгор сумд "Гал Хонгор" ХХК-ийн хийж гүйцэтгэж буй Аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээ нь нийт гэрээний дүн 6,961.1 сая төгрөг
2. Баянхонгор аймгийн Баацагаан сумд "Рино инженериинг" ХХК-ийн хийж гүйцэтгэж буй Сумын төвийн шинэчлэл нь гэрээний үнийн дүн 4,865.0 сая төгрөг
3. Баянхонгор аймгийн Баянбулаг сумд баригдаж буй 75 ортой сургуулийн дотуур байрны барилгын гэрээний үнийн дүн 2,167.1 сая төгрөг

Баянхонгор аймгийн Баацагаан сумд "Рино инженеринг" ХХК-ийн хийж гүйцэтгэж буй Сумын төвийн шинэчлэл төсөл арга хэмжээ нь анх төсөв батлагдах үед магадлал хийгдээгүйгээс төсөвт өртөг нэмэгдсэн ч төсөвт нэмэгдэж батлаагүйгээс ажил зогссон байна.

Баянхонгор аймгийн Баянбулаг сумд баригдаж буй 75 ортой сургуулийн дотуур байрны барилгын гүйцэтгэгч нь хяналт хэрэгжүүлэгчийн мэдээлж байгаагаар ажиллах хүчин багатайгаас ажил гүйцэтгэж удааширсан гэсэн тайлбар өгч байв.

Мөн дээрх арга хэмжээнүүд нь анх хэрэгжих эхлэх үед Ковид-19 цар тахлын нөхцөл байдал үүссэн нөхцөл байдалтай байсан байна.

Иймд дээрх 3 төсөл, арга хэмжээний гэрээний үүргийн биелэлтийг бүрэн хангуулж, ажлыг гүйцэтгүүлэн бүрэн хүлээн авах, мөн гэрээнд заасан нөхцлийн дагуу алданги тооцох тухай албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.

Жич: Дараах төсөл, арга хэмжээнүүдэд шинжээч ажиллуулах саналыг Үндэсний аудитын газарт хүргүүлсний дагуу зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, хөндлөнгийн шинжээч ажилласан бөгөөд дүгнэлт гарах хугацаа болоогүй байна. Үүнд:

- XVIII.1.21-Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Баянхонгор/
- XVIII.1.9 Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/
- XVII.1.52 Сумын төвийн шинэчлэл /Баянхонгор, Баацагаан сум/.
- XVII.1.47 Орон сууцжуулах төслийн дэд бүтэц /Баянхонгор, Баацагаан сум/

3.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлж, холбогдох хууль журамд нийцүүлэн хүлээн авсан уу?

Хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн тоног төхөөрөмжийг хүлээн авахдаа комисс дутуу хүлээн авсан байна.

2024 онд санхүүжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээнээс 28 төсөл, арга хэмжээний 40 багцаас зам 1, барилга байгууламж 34, тоног төхөөрөмж 5 ажил байна.

Хүснэгт № 6. Эрх шилжиж ирсэн барилга байгууламжийн хэрэгжилт

№	Төсөл арга хэмжээний нэр	Нөхцөл байдал
1	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/ Гэрээний дүн: 2,180.9 сая Гүйцэтгэгч: " Жэй энд Пи жи" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	2024 онд хэрэгжиж эхлэхээр төсөвт батлагдаж 500,0 сая төгрөгийг гүйцэтгэл гаргасан бөгөөд газар шорооны ажил, суурийн ажил, төмөр бетон карказын ажлын гүйцэтгэл гаргаж санхүүжилтээ авсан. Ажил хэвийн үргэлжилж байгаа.
2	"Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөр /Баянхонгор, Галуут сум/. Гэрээний дүн: 9,960.8 сая Гүйцэтгэгч: " Алегротовер констракшн" ХХК Гүйцэтгэл: ... хувь	Тус төсөл арга хэмжээ нь Авто замын болон халаалт цэвэр усны шугам сүлжээний ажил хийсэн, 2024 онд бохирын шугамын ажил болон цэцэрлэгт хүрээлэнгийн ажил хийж гүйцэтгэсэн боловч ажил бүрэн дуусаагүй. Цэвэрлэх байгууламж баригдаагүй.

Улс, орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

3	"Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөр /Баянхонгор, Эрдэнэцогт сум Гэрээний дүн: 5,179.9 сая Гүйцэтгэгч: " Бридж бюлдинг " ХХК Гүйцэтгэл: 100 хувь	2024 онд үлдэгдэл цахилгааны ажлын гүйцэтгэл 253.0 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилт авсан.
4	Аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/ Гэрээний дүн: 6,961.1 сая Гүйцэтгэгч: " Гал хонгор" ХХК Гүйцэтгэл: 86 хувь	Гадна дулаан 10503 м, Гадна усан хангамж 10809 м хос шугам, Ариутгах татуурга 14116 м хүчин чадалтай. ДХ12-ДХ18, ДХ5-ДХ27 дахь худгуудын газар шорооны ажил, ДХ4-ДХ7-ын бетон цутгалтын ажил, ДХ3-ДХ5, ДХ5-ДХ23, ДХ48-ДХ50, ДХ44-ДХ47 дахь худгуудын шугамын угсралт, гагнуурын ажлууд хийсэн. Гүйцэтгэл 86 хувь
5	Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/ Гэрээний дүн: 25,328.3 сая Гүйцэтгэгч: "Б-Софт" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Тус ажлыг 2024.12.20-нд комисс ажиллаж хүлээн авсан бөгөөд Гадна дулаан хангамж 4620 м, Гадна ариутгах татуурга 17100 м, Гадна цахилгаан 3800 м, Гадна холбоо 2070 м, Халаалтын зуух 15*30, 9*18 м 1 давхар УДДТөвийн барилга 12*9 м 1 давхар 2 ширхэг, Бохир усны насос станцын барилга 3,6*3,6 1 давхар 1 шилхэг Дэд өртөөний барилга 1 давхар 6 ширхэг ажлыг ашиглалтад оруулах дүгнэлт гарсан.
6	Сумын төвийн шинэчлэл /Баянхонгор, Баацагаан сум/ Гэрээний дүн: 4,865.0 сая Гүйцэтгэгч: "Рино инженеринг" ХХК Гүйцэтгэл: ... хувь	Сумын төвийн шинэчлэл ажлын хүрээнд 6х9.5 харьцаатай цэвэрлэх байгууламжийн удирдлагын байр болон 60м3-ын хүчин чадалтай 4.5х24 харьцаатай цэвэрлэх байгууламжийн суурийн цутгалтын ажил хийгдсэн. Гадна дулааны ажил ДХ1-ээс ДХ14 хүртэл 1000м урт шугам, гадна ариутгах татуургын ажил БХ1-БХ84 хүртэл 2345м урт шугам, гадна цахилгааны ажил 240кВт-ын 1 ГТП, 8 тулгуур шонгийн 435м урт цахилгааны шугамын ажил хийгдсэн.
7	"Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын ажилчдын байр, халуун усны байр /Баянхонгор, Баянхонгор сум/ Гэрээний дүн: 970.8 сая Гүйцэтгэгч: " Джихангар" ХХК Гүйцэтгэл: 52.5 хувь	Барилга угсралтын ажил үндсэн бүтээцийн цутгалтын ажил хийгдэж дууссан боловч 2-р давхрын х1-х2х-у2-у3 тэнхлэгийн хучилт, дам нуруу хотойсон байсныг 2-р давхрын угсралтыг ажлыг тор зогсоож мэргэжлийн байгууллага ирүүлж хотойсон хэсгүүдэд хэмжил хийлгүүлсэн. Барилгын төмөр бетон бүтээцүүдийн геометр хэмжээ зураг төсвийн дагуу хийгдсэн, бат бэх Б20 ангийн бетоны шаардлагыг хангасан, 2-р давхрын х1-х2х-у2-у3 тэнхлэгийн хучилтаас бусад бүтээцэд хэв гажилт, хотойлтын хэмжээ БНБД 52-101-10, БД 52-105-10-норм дүрмийн шаардлагыг хангасан. 2-р давхрын х1-х2-у2-у3 тэнхлэгийн хучилтын арматур зураг төслийн дагуу байна хучилтыг хүчилтгэх шаардлагагүй гэсэн дүгнэлт гарсан. Барилга угсралтын ажил 09 дүгээр сарын 24-ний байдлаар 1,2-р давхрын дотор гадна ханын өрлөг, агааржуулалтын системийн угсралтын ажил хийгдэж байсан. Нийт ажлын явц: 53%
8	Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 150 ор /Баянхонгор, Баянхонгор сум, 3 дугаар баг, "Дуурсах" 2 дугаар цэцэрлэг/ Гэрээний дүн: 2,600.8 сая Гүйцэтгэгч: "Шинэ өлгийн зам" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 31/2024 дугаартай барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулсан. Ашиглалт хэвийн.
9	Сургуулийн барилга, 320 суудал /Баянхонгор, Баянцагаан сум/ Гэрээний дүн: 1,317.0 сая Гүйцэтгэгч: "Навтгархайрхан" ХХК Гүйцэтгэл: 69.3 хувь	Барилгын ажил удааширсан. 2024 онд 100,0 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж бусад ажилд гүйцэтгэл гаргаж авсан. 2024 онд гадна цахилгааны станц хийсэн.
10	Сургуулийн барилга, 640 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, Соого сөйкөө сургууль/ Гэрээний дүн: 13,308.0 сая Гүйцэтгэгч: " Хөх бүрдний эх ХХК" ХХК Гүйцэтгэл: 30.0 хувь	Барилга угсралтын ажил 2024 оны 09 дүгээр сарын 30-ний байдлаар барилгын А,В,С-блокийн 1-р давхрын төмөр бетон бүтээцийн цутгалт ажил бүрэн хийгдсэн. С-блокийн 2-р давхрын бетон цутгалт хийгдсэн. А-блокийн хучилтын арматурчлал болон хэв угсралтын ажил хийгдэж байсан. Ажлын нийт гүйцэтгэл: 30%
11	Сургуулийн барилга, 640 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/ Гэрээний дүн: 6,006.3 сая Гүйцэтгэгч: " Хөх бүрдний эх" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	2024 оны төсөвт Гадна талбай, хашаа, хоолны заал, номын сан, урлагийн заалны халаалт, гадна холбооны ажлууд бүрэн хийгдэж дууссан. Шинэ суурьшлын бүсийн хөрөнгө оруулалтаар дутуу ажилд албан шаардлага өгч байсан бөгөөд аудитын үр өгөөж гарсан байна. Ажлын нийт гүйцэтгэл: 100%
12	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баянхонгор, Бөмбөгөр сум/ Гэрээний дүн: 2,551.4 сая Гүйцэтгэгч: " Номин ундрах өргөө " ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Бөмбөгөр сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга 2024 оны 09 дүгээр сарын 18-ний байдлаар барилга угсралтын ажил бүрэн хийгдэж дууссан. захиалагчийн хяналтыг нийт 5 удаа хийж хяналт хийх явцад дараах зөрчил гарсан барилгын х6-у1,х6-у2, х6-у3 тэнхлэгийн баганад хазайлт үүсэн байсныг ШУТИС БАС-ийн оношилгоо судалгааны" Бүүвэй цагаан барс" мэргэжлийн хөндлөнгийн байгууллагаар хэмжилт

		хийлгэн. Гарсан экспертийн дүгнэлтээр барилгын баганын хазайлтыг бодолцож, нэмэлт хүчитгэл хийх шаардлагагүй. Барилгын угсралтын ажлыг үргэлжлүүлэх боломжтой гэсэн дүгнэлтийг үндэслэн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлсэн. Төслийг хэрэгжүүлэх явцад өгсөн үүрэг даалгавар, барилгын норм, дүрэм, стандартыг баримтлан батлагдсан зураг төслийн дагуу хийж гүйцэтгэсэн Гүйцэтгэл 100 хувь
13	Дотуур байрны барилга, 75 ор /Баянхонгор, Баянбулаг сум/ Гэрээний дүн: 2,167.1 сая Гүйцэтгэгч: "Стандарт тоосго" ХХК Гүйцэтгэл: 82 хувь	Барилга угсралтын ажил 11 дүгээр сарын байдлаар барилгын үндсэн бүтээцийн цутгалт, шалны дулаалга, цонх, гадна ханын угсралтын ажил хийгдэж дууссан. Дээвэр, гадна фасад, дотор ханын өрлөгийн ажлууд хийгдсэн. Нийт ажлын явц: 82%
14	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Баянхонгор, Баян-Овоо сум/ Гэрээний дүн: 2,042.0 сая Гүйцэтгэгч: "Зүүн шанд" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Тус барилгыг 2021.08.13-нд комисс хүлээн авч, барилга байгууламжийг ашиглалтад оруулсан. 2024 онд санхүүжилтийг үлдэгдэл 20.5 сая төгрөг батлагдсан.
15-1	Малчдын хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын тоног төхөөрөмж /Баянхонгор/ Гэрээний дүн: 949.8 сая Гүйцэтгэгч: "Гарааны шимт боловсрол" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Сургуулийн өмнөх насны хүүхдийн шинжлэх ухаан, инженерчлэл, математик, шимтийн мэдлэгийг сайжруулах зорилгоор 8 нэр төрлийн 1498 багц тоглоомыг хүлээн авсан.
15-2	Малчдын хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын тоног төхөөрөмж /Баянхонгор/ Гэрээний дүн: 48.3 сая Гүйцэтгэгч: "Буянт хөрс наран ХХК" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Явуулын бүлгийн багшийн хичээлийн хэрэглэгдэхүүн авсан
16	Аймгийн шинэ суурьшлын бүсийн хатуу хучилттай авто зам, 10 км /Баянхонгор, Баянхонгор сум/ Гэрээний дүн: 7,995.2 сая Гүйцэтгэгч: "Түм дэлгэрэх" ХХК Гүйцэтгэл: 89.82 хувь	Аймгийн Засаг даргын 2024.09.26-ний Сангийн яаманд санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлт гаргасан албан бичигт нийт ажлын гүйцэтгэлийг 89,82 хувьтай гэж дүгнэсэн байна. Хяналтыг зөвлөх үйлчилгээний Экситос ХХК хийж гүйцэтгэсэн. Гэрээг 2025.06.01-нд дуусгахаар тусгасан.
17-1	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах ажлын гүйцэтгэл- Ингэний сүүний үйлдвэр Гэрээний дүн: 3,848.1 сая Гүйцэтгэгч: "Базардарь" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Ингэний сүүний үйлдвэрийн барилгыг ашиглалтад хүлээн авсан байсан боловч тоног төхөөрөмжийг суурилуулах явцад өртөгтөл хийх шаардлага үүсэж өргөтгөл хийсэн. Хөндлөнгийн шинжээч ажилласан.
17-2	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах Багц 4 Гэрээний дүн: 808.1 сая Гүйцэтгэгч: "Нью бест хаус" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Гадна холбооны ажлыг хийж гүйцэтгэсэн ба Шинэ суурьшлын бүсэд хийсэн хөрөнгө оруулалтын аудитаар дутуу ажлыг гүйцээх албан шаардлага өгсөн ба биелэлт тооцох хугацаа болоогүй. Хөндлөнгийн шинжээч ажилласан.
17-3	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах- шинэ суурьшлын бүсийн цахилгааны эх үүсвэрийн материал /Багц 6/ Гэрээний дүн: 1,195.0 сая Гүйцэтгэгч: "ЭН ДИ ЭМ ЭМ" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Цахилгааны материалыг нийлүүлсэн ба аймгийн "Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК ажлыг хийж гүйцэтгэсэн. Хөндлөнгийн шинжээч ажилласан.
17-4	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Багц 2/ Ногоон тэжээлийн үйлдвэрийн ажил Гэрээний дүн: 2,584.8 сая Гүйцэтгэгч: "БЭНЖЦЭС" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Тус арга хэмжээ нь өвлийн 3 хүлэмж барих ажил бөгөөд хүлэмжийг хүлээн авч байнгын ашиглалтад оруулсан байна. Хөндлөнгийн шинжээч ажилласан.
17-5	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Багц 3/ Мах ногооны 1000 тн зоорийн барилга Гэрээний дүн: 3,074.9 сая Гүйцэтгэгч: "Сант-Өндөр" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Тус зоорины барилгын ажлыг хийж гүйцэтгэсэн ба тоноглох ажил хийж дууссан байна. Тус барилгыг сэндвичээр барьсан. Хөндлөнгийн шинжээч ажилласан.
17-6	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/ цэвэрлэх байгууламж Гэрээний дүн: 450.0 сая Гүйцэтгэгч: "Алтайн эколог" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Цэвэрлэх байгууламжийг ТОПЭРО төхөөрөмжийг суурилуулан хүлээлгэн өгсөн. Хөндлөнгийн шинжээч ажилласан.
18-1	Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл -ХАА МАШИН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ Гэрээний дүн: 2,835.2 сая Гүйцэтгэгч: "ЭМ ЭН ЮУ" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Тоног төхөөрөмжийг жагсаалтаар хүлээн авсан.
18-2	Хөдөө аж ахуй Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Багц 1: ХАА кластерийн барилга байгууламжийн ажил Гэрээний дүн: 3,315.1 сая Гүйцэтгэгч: "Татах хүч" ХХК Гүйцэтгэл: 90-95 хувь	Сэндвичээр ногоон тэжээлийн үйлдвэрийн барилга болон Авто грахын, агуулахын барилгыг барьсан ажилчдын байрыг үндсэн бүтээц хийсэн дотор заслын ажил хийж байна.


18-3	Хөдөө аж ахуй Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Багц 2: Гүн өрмийн худаг, хашаажуулалтын ажил Гэрээний дүн: 373.9 сая Гүйцэтгэгч: " Номгоны андууд" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Гүн өрмийн худгийг ажил бүрэн хийсэн байна.
18-4	Хөдөө аж ахуй Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Багц 5: ХАА кластерийн гадна тохижилт хүрмэн бетон хашааны ажил Гэрээний дүн: 1,174.0 сая Гүйцэтгэгч: " Гичгэнэ хяр " ХХК Гүйцэтгэл: 83 хувь	Гадна тохижилтын ажлын шугаман суурьтай блок хашаа хийсэн боловч хөрс намгархаг овой хөлддөг газарт хашаа хийснээс нурж хашааг сольсон боловч бүрэн хийгээгүй.Ажилд шинжээч ажилласан.
18-5	Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Баянхонгор/ (Багц-6) Хүлэмжийн барилгын ажил Гэрээний дүн: 1,678.0 сая Гүйцэтгэгч: " Елбата " ХХК Гүйцэтгэл: 45.3 хувь	Нийт 5 өвлийн хүлэмжийн барилгыг барьж дуусгасан.
18-6	Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Баянхонгор/Багц3. Дэд станц, Баянлиг сумын тариалангийн талбайн цахилгааны дэд станц барих ажил Гэрээний дүн: 191.3 сая Гүйцэтгэгч: " Гарьд системс " ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Дэд станцын ажлыг хийж хүлээлгэн өгсөн.
18-7	Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Баянхонгор/Багц3. Дэд станц, Баянлиг сумын тариалангийн талбайн цахилгааны дэд станц барих ажил Гэрээний дүн: 919.9 сая Гүйцэтгэгч: " Боршоон ундраа" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	630кВт/04-өөс 630м урт цахилгааны шугам болон 16ш гэрлийн шонг суурилуулах ажил, кабель шугамын ажил, Дулааны худаг 1-ээс дулааны худаг 6 хүртэлх 564м дулааны шугамын ажил, Оффисын барилгаас гарсан ариутгах татуургын 19.1м урт шугам, ариутгах татуургын анхны худаг болон 10м3 хүчин чадалтай сорох зориулалттай цэвэрлэх байгууламжийг хийж гүйцэтгэсэн байна.
19	Малчид болон орон нутгийн хөгжлийг дэмжих "Мал аж ахуйн салбарын эдийн засгийн үр ашиг, хөдөлмөрийн бүтээмж" төслийн тоног төхөөрөмж /Баянхонгор/ Гэрээний дүн: 800.0 сая Гүйцэтгэгч: " Бест агро интернэйшнл " ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Тус төсөл арга хэмжээний 4 төрлийн 790 ширхэг техник хэрэгсэл хүлээн авсан. Цахилгаан хадуур 450 ш, Сүүний машин 210 ш, Малын байршил тогтоогч 120 ш, Олон үйлдэлт трактор 10-ийг хүлээн авсан.
20	"Шинэ хөдөө" төсөл /Баянхонгор/ Гэрээний дүн: 2,796.4 сая Гүйцэтгэгч: " Эм эн юу ХХК " ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Төслийн хүрээнд 2024.07.10-ний өдөр 36 нэр төрлийн 507 ширхэг 1,862,537,860 төгрөгийн үнэ бүхий, 2024.10.02-ний өдөр 55 нэр төрлийн 340 ширхэг 846,382,000 төгрөгийн Нийт 543 нэр төрлийн 563 ширхэг 2,708.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна.
21	110/35/6 кВ-ын Баянхонгор дэд станцын өргөтгөл, шинэчлэл /Баянхонгор/ Гэрээний дүн: 13,296.7 сая Гүйцэтгэгч: " ДМТМ ТРЕЙД " ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Тухайн төсөл арга хэмжээг 2024.12.23 -нд комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авсан.
22	Эрүүл мэндийн төвийн барилга /Баянхонгор, Хүрээмарал сум/ Гэрээний дүн: 1,463.7 сая Гүйцэтгэгч: " Зураан даваа " ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Барилгыг 2023.11.10-нд байнгын ашиглалтад хүлээн авсан бөгөөд ашиглалтын явцад дээврээс ус гоождог, цонхны битүүмж муугаас дулаан алдагдал, их шороо ордог эмчийн байрны болон гаржийн дээврээс ус гоождог.
23	Наркологийн төв эмнэлгийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/ Гэрээний дүн: 7,494.1 сая Гүйцэтгэгч: " Итгэлт тайж" ХХК Гүйцэтгэл: 23.0 хувь	Барилга угсралтын ажил 11 дүгээр сарын 6-ний байдлаар гадна инженерийн шугамын ажлууд болон үндсэн бүтээцийн зоорины давхрын цутгалтын ажлууд бүрэн хийгдэж дууссан. Ажлын нийт гүйцэтгэл: 23%
24	Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Баянхонгор/ Гэрээний дүн: 894.4 сая Гүйцэтгэгч: " Сүвэн уул " ХХК Гүйцэтгэл: 100.0 хувь	Тоног төхөөрөмжийг 2024.12.23-ний өдөр хүлээн авсан бөгөөд нийт 27 нэр төрлийн 103 ширхэг 894.4 төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хүлээн авсан байна.
25	Усан бассейн спорт цогцолборын барилга /Баянхонгор, Баянхонгор сум/ Гэрээний дүн: 11,899.4 сая Гүйцэтгэгч: " РМВ " ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Барилгын ажлыг гүйцэтгэж 2022.12.05-ны өдөр барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан. Магадлалын дүгнэлт хийсэн зөрүүг 2024 оны төсөвт 100.0 сая төгрөгөөр баталж өгсөн байна. 2025 онд үлдэгдэл төсөв баталсан.

26	Биеийн тамир, спортын салбарын тоног төхөөрөмж /Баянхонгор/ Гэрээний дүн: 569.5 сая Гүйцэтгэгч: "Тэнгэрийн уул" ХХК Гүйцэтгэл: 100 хувь	Нийт 54 нэр төрлийн 569,543,140 төгрөгийн хөрөнгийг хүлээн авсан гэж комиссын актыг 2024.07.18-ны өдөр үйлдэн хүлээн авсан.
27	Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Заг сум/ Гэрээний дүн: 4,495.1 сая Гүйцэтгэгч: "Энх баялаг констракшн" ХХК Гүйцэтгэл: 33.8 хувь	Тус барилга анх гүйцэтгэгч 1,519.2 мянган төгрөгөөр гэрээ хийж байсан боловч төсөл арга хэмжээ 2020 оны 2 дугаар сард 1,548.2 сая төгрөгөөр магадлалын дүгнэлт гарч байсан бол 2023.09.29 нд 4,536.8 мянган төгрөгөөр дахин магадлалаар орж төсөвт өртөг нэмэгдсэн байна. Барилга угсралтын ажил 2024 оны 07 дугаар сарын байдлаар 1 дүгээр давхрын цутгалт хийгдээгүй байсан нийт 14 баганын цутгалтын ажил хийгдсэн.
28	Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Улсын хэмжээнд/ Багц 2.1: Орон нутгийн цахилгаа Гэрээний дүн: 418.8 сая Гүйцэтгэгч: "Гарьд системс" ХХК Гүйцэтгэл: 33.8 хувь	Орон нутгийн цахилгаан хангамжийн өргөтгөл, шинэчлэлт /Баянхонгор аймаг, сумд/ ажлыг бүрэн хэрэгжүүлж дууссан байна. Үүнд: • 6 сумын 0.4кВ-ын ЦДАШ-ын угсралт, өргөтгөл, шинэчлэлт хийгдсэн • 3 сумын ачаалал ихтэй дэд станцын хүчний трансформаторуудыг сольж хүчин чадлыг нэмэгдүүлсэн • Амарбуянтын хийдэд аккумуляторын батарей 50ш, инвертер 1000А 2ш шинээр суурилуулж хуучин дэлгэцүүдийг шалгаж холболт кабелиудыг шинэчилж гэрэлтүүлэг нэмэгдүүлж шит самбаруудыг сольж шинээр 6ш дэлгэц суурилуулж аккумуляторын батарей 4ш бүхий инвертер угсарч 3,5 квт хүчин чадалтайгаар шинэ дуганыг нарны цахилгаан үүсгүүрээр хангасан байна

Аудитаар дээрх төсөл арга хэмжээнүүдэд ажиллахад дараах төрлийн зөрчлүүд илрэв. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- Баянбулаг сумын дотуур байрны барилгын ажлын хана, хамар өрөхдөө зай завсар ихтэй битүүмж хийгээгүй, гадна хөөсөн дулаалгаа хийхдээ хана хэсгээс хөндий зайтай хийж гүйцэтгээсэн байна.
- Хүрээмарал сумын ЭМТ-ийн барилгыг 2023.11.10-нд байнгын ашиглалтад хүлээн авсан бөгөөд ашиглалтын явцад дээрээс ус гоождог, цонхны битүүмж муугаас дулаан алдагдал, их шороо ордог эмчийн байрны болон гаржийн дээрээс ус гоождог



Хүрээмарал ЭМТ Ус нэвчсэн байдал



Баянбулаг дотуур байр өрлөгийн завсар болон хөөс хананы хоорондох зай



Дээрх ажилд захиалагч явцын хяналтыг хийж дараах үүрэг даалгаврыг өгсөн байна. Үүнд:

- Өрлөгийн шаврыг баг хийх

- ХАБЭА-н зааварчилгааг тогтмол өгч, тэмдэглэл хөтлөн, аюулгүй ажиллагааг тогтмол ханган ажиллах.
- Өмнө өгсөн үүрэг даалгаврын биелэлт гаргах
- Зохигчийн хяналт хийлгэх
- Бетон хийцийн сорилтын үр дүнг баримт бичигт хийх. Барилгын тухай хуулийн 40.1.12 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах
- Тохирлын гэрчилгээтэй материал ашиглах

Иймд дээрх төсөл, арга хэмжээнүүдэд улсын байцаагчийн хяналт хийлгэж, зөрчлийг арилгах албан шаардлагыг ГХБХБГ-т хүргүүлэв.

Мөн гэрээний үүргээ хугацаандаа бүрэн биелүүлдэггүй, удаа дараа чанаргүй ажил хийж гүйцэтгэдэг гүйцэтгэгчийг Сангийн яамны хар жагсаалтад оруулж цаашид гэрээ байгуулахгүй байж, хариуцлагыг сайжруулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт:

Биеийн тамир, спортын салбарын тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд Тэнгэрийн уул ХХК нь 569.5 сая төгрөгөөр гэрээ байгуулж, тоног төхөөрөмжийг 2024.07.10-ний өдөр хүлээлгэн өгсөн боловч Волейболын шал 12.8 сая, Үндэсний шагайн харвааны иж бүрдэл 4.6 сая нийт 17.4 сая төгрөгийн хөрөнгийг дутуу нийлүүлсэн байна.

Иймд дутуу нийлүүлсэн хөрөнгийн 17.4 сая төгрөгийг Тэнгэрийн уул ХХК-аар улсын төсөвт буцаан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож Төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг техникийн тодорхойлолтын дагуу иж бүрэн хүлээн авч байх зөвлөмжийг Орон нутгийн өмчийн газарт өгөв.

Тус төсөл, арга хэмжээний хүрээнд нийлүүлсэн зарим техник, хэрэгсэл үнийг түүвэрлэн судалгааг хийж үзэхэд зах зээлийн үнээс хэт өндөр үнээр нийлүүлэхээр тендерийн санал ирүүлсэн, техникийн тодорхойлолтод тавьсан шаардлагад хүрэхгүй хэрэгслэл багтсан байна. Тухайлбал:

- Үндэсний харвааны нум сумын иж бүрдлийн зах зээлийн үнэ 1,500.0 мянган төгрөг, байхад нийлүүлсэн үнэ 2525.0 мянган төгрөг,
- Байт харвааны нум сум иж бүрэн зах зээлийн үнэ 1,670.0 мянган төгрөг, нийлүүлсэн үнэ 4,405.0 мянган төгрөг,
- Гүйлтийн цана зах зээлийн үнэ 850.0 мянган төгрөг байхад нийлүүлсэн үнэ 1,652.0 мянган төгрөг төгрөгөөр нийлүүлсэн байна.

(мэргэжлийн холбоод, дасгалжуулагчаас өгсөн мэдээлэлд үндэслэв)

Чанаргүй буюу зах зээлийн үнээс өндөр нийлүүлсэн гэсэн шалтгаанаар зарим спортын төрлийн техник хэрэгсэлийг холбогдох спортын холбоод хүлээн аваагүй байна.

Иймд уг төсөл, арга хэмжээний нийлүүлэлтийн талаар Гүйцэтгэгчээс ирүүлсэн тайлбараас үзэхэд гүйцэтгэгчээс бус захиалагчийн техникийн тодорхойлолттой холбоотой үүссэн зөрчил бөгөөд бүхэлдээ залилангийн шинж агуулж байж болзошгүй тул Прокурорын байгууллагаар шалгуулах саналыг МҮЕА-т хүргүүлэв.

3.4. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна уу?

Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг бүрэн бүртгэж, ашиглалтын ил тод байдал, үр өгөөжийг сайжруулах шаардлагатай байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 30,495.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл арга хэмжээ ашиглалтад орсноос ТӨБЗГ-ын 2024 оны 517 дугаар тогтоолоор 6,942.2 сая төгрөгийн 2 барилгыг нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.

Мөн өмнөх онуудад ашиглалтад орсон барилгыг бүртгэл дараах байдлаар бүртгэсэн байна.

- Баян-Овоо сумын 150 ортой Цэцэрлэгийн барилгыг Аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 11 дүгээр 13-ны өдрийн 107 дугаар захирамжаар эзэмшигчийг тогтоон бүртгэсэн.
- “Баянхонгор аймгийн Шинэ суурьшлын бүсэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа арга хэмжээ, бүтээн байгуулалт” гүйцэтгэлийн аудитаар Шинэ суурьшлын бүсэд баригдаж 2021 оны 11 дүгээр сард улсын комисс хүлээн авсан 5,166.1 сая төгрөгийн 640 хүүхдийн сургууль ашиглалтад орсон боловч бүртгэлд тусгаагүй байсанд албан шаардлага өгч аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 107 дугаар захирамжаар эзэмшигчийг тогтоож бүртгэсэн.
- Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн барилгыг эзэмшигч тогтоож, бүртгэлд тусгааар тогтоолын төслийг аймгийн ОНӨГ-аас аймгийн ИТХ-д хүргүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон 8 төсөл арга хэмжээний 40,112.2 сая төгрөгийн хөрөнгөд эзэмшигч тогтоож хөрөнгийн бүртгэлд тусгах асуудал шийдвэрлээгүй байна.

Нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байгаа нь төсөл арга хэмжээний ихэнх нь 2024 оны сүүлээр Улсын комисст хүлээлгэн өгсөнтэй холбоотой бөгөөд НББ-д бүртгүүлэх хүсэлтийг холбогдох газруудад уламжлах ажил хийгдэж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4³, 6.2⁴, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4⁵ дэх заалтуудтай нийцэхгүй тул хөрөнгийн эзэмшигчийг тогтоож, данс бүртгэлд тусгах албан шаардлагыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэв.

Аудитаар хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний хөрөнгийн ашиглалтын байдлыг газар дээр нь очиж шалгахад зарим хөрөнгө нь ашиглалтгүй байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

- Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний ажлыг Б-Сорт компани 25,328.3 сая төгрөгөөр гүйцэтгэж 2024.12.20-нд хүлээн авсан боловч бүрэн хүчин чадлаар нь ашиглаж эхлээгүй

³ - Хандив, тусламж, бэлэглэл, өвлөх журмаар олж авсан эд хөрөнгө

⁴ - Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.

⁵ - Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.

- Шинэ хөдөө төслийн хөрөнгө оруулалтаар ирсэн Баянхонгор үйлдвэрлэл хөгжлийн корпорац ОНӨҮГ-т хуваарилсан Кителийн 80 ш тоног төхөөрөмж ирснээс 371.3 сая төгрөгийн 52 ш нь ашиглалт байхгүй.
- Хөдөө аж ахуйн кластер төслүүдийн хүрээнд бий болж буй Ингэний сүүний үйлдвэр, 1000 тн зоорь, өвлийн хүлэмжүүд зэрэг томоохон бүтээн байгуулалт ашиглалтагүй байна.

Гэр хорооллын шугам сүлжээг айл өрхтэй холбох ажлыг зохион байгуулах зорилгоор 2025 онд орон нутгийн төсөвт 800.0 сая төгрөгийг баталж төв магистрал шугамаас айл өрхүүдэд ойртуулахаар төлөвлөсөн байна.

Мөн айл өрхөд халаалтын эх үүсвэрт холбоход Монгол банк болон банк санхүүгийн байгууллагуудаас хөндөлттэй зээлд хамрагдах асуудлыг судалж байгаа талаар бодлого хариуцсан хэлтсийн холбогдох албан тушаалтнууд тайлбар өгч байв.

Иймд хөрөнгө оруулалтаар бий болсон томоохон бүтээн байгуулалт болон үйлдвэрлэлийг бүрэн ашилаж хөрөнгийн үр ашгийг гаргах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт:

Хөдөө аж ахуйн кластер төслийн хүрээнд " Алтайн эколос " ХХК-ийн хийж гүйцэтгэсэн цэвэрлэх байгууламжийн 1 блок шатсан ба одоогийн байдлаар ашиглалт байхгүй байгальд саарал усыг цэвэрлэхгүйгээр хаяж байна. Энэхүү асуудлыг Шинэ суурьшлын бүсийн аудитаар зөвлөмж өгсөн ба хэрэгжилт тооцох хугацаа болоогүй байна.

Аудитаар нийт 40,559.4 сая төгрөгийн зөрчил илрүүлж 17.4 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 40,140.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага өгч, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 401.9 сая төгрөгийн 8 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлэв.

-оОо-

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. 2024 онд Баянхонгор аймагт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь улс болон орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан боловч, зарим тоног төхөөрөмж ашиглалгүй байгаагаас үзэхэд эдийн засгийн тооцоо, шинжилгээ болон төлөвлөлт муу, төрийн байгууллагын хоорондын уялдаа холбоо сул байна.
2. УИХ-аар зураг төсөлгүй, магадлал хийгдээгүй төсөл арга хэмжээ батлагддагаас шалтгаалан Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтыг хангаагүй зөрчил арилахгүй, төсөвт өртөг нэмэгдэх байдал их байна.
3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хугацаанд нь баталж, цахим системийн хэрэгжилтийг ханган, тендерийн үйл явцыг ил тод, нээлттэй зохион байгуулсан боловч үнэлгээний хороо зарим тендерийн шалгаруулалтад шаардлага хангаагүй оролцогчийг сонгосон байна.
4. Санхүүжилтийг зохиогчийн болон захиалагчийн хяналтын тайлан ажлын тоо хэмжээ нэг бүрээр тулгаж олгосон байна.
5. Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт хяналт хэрэгжүүлэх хүний нөөцийн хүрэлцээ дутмаг байгаагаас хяналтыг чанартай гүйцэтгэж чадахгүй байна.
6. Төсвийн тухай хуулиар хэрэгжиж дуусах хугацаа болсон гэрээний хугацаа дууссан 3 төсөл, арга хэмжээний хэрэгжилт бүрэн дуусаагүй байна.
7. Хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн тоног төхөөрөмжийг хүлээн авахдаа комисс дутуу хүлээн авсан байна.
8. Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг бүрэн бүртгэж, ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

-оОо-

ЗӨВЛӨМЖ:

НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНХОНГОР ИТХ-Д ТОЛИЛУУЛАХ НЬ:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж ашиглалтад орсон Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээ, Хөдөө аж ахуйн кластер төслийн хүрээнд бий болсон Ингэний сүүний үйлдвэр, мах ногооны зоорь, өвлийн хүлэмж зэрэг томоохон төсөл арга хэмжээг бүрэн ашиглаж хөрөнгийн үр ашгийг гаргах бодлого чиглэлийг эрчимжүүлэх шийдвэр гаргах шаардлагатай байна.

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА:

1. Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон томоохон бүтээн байгуулалт, жижиг дунд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогыг холбогдох мэргэжлийн агентлаг, хэлтсүүдийг оролцуулсан ажлыг зохион байгуулж тодорхой шийдлийг гарган хэрэгжүүлэх.
2. Тендерийн баримт бичгийн техник болон хууль эрх зүйн шаардлагыг салбарын холбогдох хуульд нийцүүлэн боловсруулж байх, шалгуур үзүүлэлтийг харьцуулах боломжтой тодорхой, ойлгомжтой оруулж байх.
3. Гэрээний үүргээ хугацаандаа бүрэн биелүүлдэггүй, удаа дараа чанаргүй ажил хийсэн гүйцэтгэгчийг Сангийн яамны хар жагсаалтад оруулах хүсэлтийг уламжлах.
4. Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.9 -д заасны дагуу зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хуулийн этгээдээр хяналтыг гүйцэтгүүлэх асуудлыг судалж, захиалагчийн хяналтыг сайжруулах.

ХОЁР. БАЯНХОНГОР АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА Н.БЯМБАДОРЖ ТАНАА:

5. Тендерийн баримт бичигт туссан ерөнхий шаардлагыг үнэлэх талаар үнэлгээний хорооны гишүүдэд арга, зүйн зөвлөгөө өгч ажиллах.
6. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан зах зээлийн үнийн судалгаа хийх үүргээ хэрэгжүүлж ажиллах.

ГУРАВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА М.МӨНХБАТ ТАНАА:

7. Төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулж, хөрөнгийг техникийн тодорхойлолтын дагуу иж бүрэн хүлээн авч байх.
8. Шинэ хөдөө, Мал аж ахуйн салбарын эдийн засгийн үр ашиг, хөдөлмөрийн бүтээмж төслийн хүрээнд Баянхонгор аймагт Улсын төсвийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн ашиглалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 05-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.